



**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**

**БИЕЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ
ХОЛБООТОЙ ИРГЭНИЙ ГАРГАСАН ГОМДЛЫН ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН
ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ДОТООД ХЯНАЛТЫН ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2026 он**

БИЕЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ИРГЭНИЙ ГАРГАСАН ГОМДЛЫН ДАГУУ ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2026 оны 02 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын яаманд 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр иргэн М.Гэрлээгийн гаргасан гомдол, Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрамд 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр гаргасан гомдол, Авлигатай тэмцэх газрын 2025 оны 12 дугаар сарын 11-ний 03/21021 дүгээр “Гомдол шилжүүлэх тухай” албан бичиг, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 04/1236 дугаар албан бичгээр ирүүлсэн иргэн М.Гэрлээгийн гомдол гэсэн нийт 4 гомдолд дурдагдсан асуудлаар дотоод хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах зорилгоор шалгалтыг гүйцэтгэлээ.

Батлагдсан удирдамжийн “Тав.Хяналт шалгалтын хамрах хүрээ, чиглэл” хэсэгт заасны дагуу гомдолд дурдсан дараах асуудлаар дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн болно.

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ТОГТООГДСОН БОДИТ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. М.Гэрэлээ гомдолдоо “...Нийслэл дэх захиргааны хэргийн шүүхэд Биеийн тамир, спортын улсын хорооноос миний 2024 оны гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг нотлох баримтаар ирүүлээгүй...” гэснийг шалгахад:

Нийслэл дэх захиргааны хэргийн шүүхэд “Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Б/84 дүгээр тушаалыг хүчингүй болгуулах, Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн Спортын тэмцээн наадмын тогтолцоо, зохион байгуулалтын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтний албан тушаалд эгүүлэн томилуулах, ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх олгооврыг хариуцагчаас гаргуулах, ажилгүй байсан хугацааны нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хуульд зааснаар хариуцагчаас нөхөн төлүүлэх” нэхэмжлэгчийн шаардлагатай шүүх хуралд Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгтийн 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 1/138 дугаар албан бичиг болон албан тушаалын чиг үүргийн дагуу Нийслэл дэх захиргааны хэргийн шүүхэд Биеийн тамир, спортын улсын хороо (цаашид хороо гэх)-г төлөөлөн оролцох эрхийн дагуу тус хорооны хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн С.Номин хариуцсан ажилласан байна.

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 01/3022 дугаар “Нотлох баримт гаргуулах тухай” албан бичигт дараах баримтуудыг шүүхэд гаргуулахаар албан бичиг ирүүлжээ. Үүнд:

1. Иргэн М.Гэрлээгээс Биеийн тамир, спортын улсын хорооны спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Ж.Баасансүрэнд хандан “Амралтын өдрүүдэд ажилласан хугацааг нөхөж олгох” хүсэлт гаргасны дагуу тус хорооны даргаас өгсөн хариу болох 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 04/09/82 дугаар албан бичиг;
2. Биеийн тамир, спортын улсын хорооны Ёс зүйн дэд хорооны 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 02 дугаар дүгнэлт;
3. Биеийн тамир, спортын улсын хорооны Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн Спортын тэмцээн наадмын тогтолцоо, зохион байгуулалтын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн М.Гэрлээгийн 2024 оны эхний хагас жилийн болон жилийн эцсийн ажлын гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлсэн үнэлгээний хуудас...гэжээ.

Тус албан бичгийн дагуу Биеийн тамир, спортын хорооноос нотлох баримт болох нийт 161-н хуудас материалыг Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан хүргүүлсэн байна.

Шүүхэд итгэмжлэгдэн төлөөлөгчөөр оролцсон хуулийн ахлах мэргэжилтэн С.Номиноос тайлбар авахад “...М.Гэрлээгийн 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээний хуудас байхгүй байсан нь үнэн, харин БТСУХ-ны даргын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Б/89 дүгээр тушаалын хавсралтаар М.Гэрлээ 73.8 хувиар гүйцэтгэлээ үнэлүүлснийг нотлох баримтын шаардлага хангуулан шүүхэд гаргаж өгсөн. Миний бие иргэн М.Гэрлээгийн 2024 оны жилийн эцсийн үнэлгээний хуудас алга болсныг мэдэхгүй, тухайн үед хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Н.Анар мэдэхгүй байсан тул олж өгөөгүй” гэсэн тодруулга өгсөн.

Үүнээс дүгнэхэд М.Гэрлээгийн Биеийн тамир, спортын улсын хороонд ажиллаж байх үеийн буюу 2024 оны жилийн эцсийн Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх үнэлгээний хуудсыг нотлох баримтаар Шүүхэд хүргэгдээгүй байна.

Хоёр. М.Гэрлээ гомдолдоо “... Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Баттулгын гаргасан 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Б/71 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх үнэлгээ-г хийх үнэлгээний багийн ахлагч О.Гэрэл, нарийн бичгийн дарга Б.Нармөнх нар тушаалаар үүрэг болгосон чиг үүргээ хэрэгжүүлээгүй, Спортын хэлтсийн дарга Ж.Баасансүрэн үнэлгээний багийн гишүүнээр томилогдон ажиллахдаа тушаалаар хүлээсэн үүргээ хийгээгүй, Спортын бодлогын хэлтсийн 4 албан хаагчийн 2024 оны жилийн эцсийн “Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх үнэлгээ”-г огт хийгээгүй”... гэснийг шалгахад:

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн “Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл үр дүн мэргэшлийн түвшнийг үнэлэх үнэлгээний баг байгуулах тухай” Б/71 дүгээр тушаалын хавсралтаар Үнэлгээний багийн бүрэлдэхүүнийг баталсан байна. Үүнд:

Үнэлгээний багийн ахлагч: Бодлого, төлөвлөлтийн газрын дарга О.Гэрэл,
Гишүүдэд: Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Ж.Баасансүрэн
Биеийн тамир, спортын хэрэгжилтийн хэлтсийн дарга О.Баасан,
Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтсийн дарга Н.Оюунбат
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Н.Батсүх
Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэрэнболд
Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Э.Билэгт,
Салбарын төсвийн бодлого, төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах
мэргэжилтэн Г.Эрдэнэцогт,
Салбарын мэдээлэл, технологийн бодлогын зохицуулалт, аюулгүй байдал
хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Лхагваням
Нарийн бичгийн дарга: Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Б.Нармөнх
нарын 10 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажилласан байна.

Тус үнэлгээний баг 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр хуралдахад 2
гишүүн чөлөөтэй байсан тул ирц 67 хувьтай хуралдаж, нарийн бичгийн дарга
хурлын тэмдэглэлийг хөтөлсөн байна. Хурлаар 35 албан хаагчийн гүйцэтгэлийн
тайланг үнэлж 2024 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг хянаж “маш
сайн” үнэлгээний ангилалд 28 албан хаагч, хэвийн үнэлгээний ангилалд 6 албан
хаагчийн ажлыг үнэлж баталгаажуулсан. Үлдсэн 1 албан хаагчийн буюу
М.Гэрлээгийн ажлыг үнэлээгүй байна.

Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн 4 албан хаагчийн Төрийн албан
хаагчийн ажлын гүйцэтгэл үр дүн мэргэшлийн түшинг үнэлэх үнэлгээний хуудсыг
2026 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр БТСУХ-оос баримтаар гаргаж ирүүлсэн.
Ирүүлсэн баримтыг шалгахад Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон мэргэжлийн
спортын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Э.Хүрэлчулуун, Үндэсний
болон баг, өвлийн спортын бодлогын хэрэгжилтийг хариуцсан мэргэжилтэн
Д.Мөнхбаяр, Аймаг нийслэлийн биеийн тамир, спортын байгууллагын асуудал
хариуцсан мэргэжилтэн М.Наранбадрах нарын 3 албан хаагчийн Төрийн албан
хаагчийн ажлын гүйцэтгэл үр дүн мэргэшлийн түвшнийг үнэлэх үнэлгээний хуудаг
үнэлгээний багийн гишүүд үнэлгээ өгч гарын үсэг зурсан, Биеийн тамир, спортын
улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Баттулга гарын үсэг
зурж байгууллагын тамгаар баталгаажуулсан байна.

Харин Спортын тэмцээн наадмын тогтолцоо, зохион байгуулалтын бодлого
хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн М.Гэрлээгийн Төрийн албан хаагчийн ажлын
гүйцэтгэл үр дүн мэргэшлийн түвшнийг үнэлэх үнэлгээний хуудаг 73.78 хувийн
үнэлгээ өгч Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Ж.Баасансүрэн гарын
үсэг зурсан ба бусад холбогдох албан тушаалтан гарын үсэг зураагүй
баталгаажуулаагүй байна.

Спортын тэмцээн наадмын тогтолцоо, зохион байгуулалтын бодлого
хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн М.Гэрлээгийн 2024 оны жилийн эцсийн ажлын
гүйцэтгэл үр дүн мэргэшлийн түвшнийг үнэлэх үнэлгээг үнэлж баталгаажуулаагүй

асуудлыг Соёл, спорт аялал жуулчлал залуучуудын сайдын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр баталсан “Биеийн тамир, спортын улсын хорооны үйл ажиллагаанд иргэний гаргасан гомдолд дурдсан асуудлаар дотоод хяналт шалгалт хийх удирдамж”-ийн хүрээнд дотоод хяналт шалгалтаар шалган тогтоон тайлан, зөвлөмжийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 12/2031 дүгээр албан бичгээр Биеийн тамир, спортын улсын хорооны албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгт болон хувийг гомдол гаргагч М.Гэрлээд тус тус хүргүүлсэн байна. Тус тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллаагүй байна.

Гурав. М.Гэрэлээ гомдолдоо “...Спортын бодлогын хэлтсийн 4 албан хаагчийн 2024 оны жилийн эцсийн “Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх үнэлгээ”-г хийгээгүй байж үр дүнгийн урамшуулал болон 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/749 дүгээр “Нэмэлт санхүүжилтийн орлогыг зарцуулах тухай тушаал албан хаагч бүрд 2,400.0 мянган төгрөг олгосон...” гэснийг шалгахад:

Тус хорооны Спортын бодлогын хэлтсийн 4 албан хаагчийн 3 албан хаагчийн 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлгээний баг үнэлж баталгаажсан. Энэ үнэлгээнд үндэслэж 2024 оны албан хаагчийн үр дүнгийн урамшуулал болон БТСУХ-ны даргын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/749 дүгээр “Нэмэлт санхүүжилтийн орлогыг зарцуулах тухай” тушаалаар тус бүр 2,400.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 51.1.1.4 дэх заалт “Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох” , Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2 дахь заалт “Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно”, Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 7.3.2 дахь заалт “Байгууллагын хамт олон, ажилтныг ажлын үр дүнг нь харгалзан урамшуулах” гэсэн заалтын дагуу олгосон тул хууль тогтоомжид нийцсэн байна.

Дөрөв. М.Гэрэлээ гомдолдоо “Биеийн тамир, улсын хорооны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн хяналт-шинжилгээний мэргэжилтэн Н.Дүнжиймаа албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан эсэх эргэлзээтэй” гэсэн асуудлыг шалгахад:

Орон нутгийн байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Н.Дүнжиймаа нь Биеийн тамир, спортын улсын хорооны даргын Б/113 дугаар тушаалаар 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газраас Тогтоол шийдвэрийн биелэлт гүйцэтгэл, гүйцэтгэлийн төлөвлөгөө хариуцсан мэргэжилтний албан тушаалаас шилжин томилогдсон байна.

Мэргэжилтэн Н.Дүнжиймаагийн боловсролын түвшин, эзэмшсэн мэргэжил, ажилласан туршлагыг түүний хашиж буй албан тушаалын тодорхойлолтыг хангаж байгаа эсэхийг шалгахад Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 309 дүгээр тогтоолын 41 дүгээр хавсралтаар батлагдсан “Орон нутгийн байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн”-ний албан тушаалын мэргэжлийн тусгай шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал: Албан тушаалын тодорхойлолтод Эрх зүй/042/, Спорт/1014/ Төрийн удирдлага/041303/ Спортын менежмент гэсэн мэргэжлийг заасан байхад Н.Дүнжиймаа нь Улс төр судлаач мэргэжилтэй байна.

Албан тушаалын тусгай шаардлага хангаагүй албан тушаалтныг шилжүүлэн томилсон нь Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4.2-т заасан “Төрийн жинхэнэ ... Төрийн жинхэнэ албан хаагч тухайн албан тушаалын тусгай шаардлагыг хангаж буй тохиолдолд адил төрлийн албан тушаалын адил ангилалд шилжүүлэн ажиллуулахдаа тусгай шалгалтгүйгээр шууд томилно” гэснийг зөрчсөн.

Тав. Биеийн тамир, спортын улсын хорооны даргад хандан иргэн М.Гэрлээгийн 2025 оны 11 дүгээр сарын 11 болон 17-ны өдөр гаргасан гомдлын шийдвэрлэлтийг шалгахад:

Тус хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгтэд хандан иргэн М.Гэрлээгийн 2025 оны 11 дүгээр сарын 11 болон 17-ны өдөр даргын туслах Н.Дашдаваагийн ажлын байран дээрээ согтууруулах ундаа хэрэглэсэн байсан тухай, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн ерөнхий нягтлан бодогч Н.Оюунцэцэг албан тушаалаа урвуулан ашиглаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын албан даалгаврын хүрээнд ажлаас чөлөөлөгдсөн иргэнийг нярваар ажиллуулсан тухай гомдлуудыг тус тус гаргасан байна. Энэ гомдлуудыг бичиг хэргийн ажилтан 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр бүртгэн авч, даргын цохолтоор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст шилжүүлж, гомдлыг мэргэжилтэн Н.Дүнжиймаад хуваарилагдсан байна.

5.1 Мэргэжилтэн Н.Дүнжиймаа “даргын туслах Н.Дашдаваагийн ажлын байран дээрээ согтууруулах ундаа хэрэглэсэн” тухай гомдлыг хүлээн авч гомдолд дурдсан албан хаагчдаас ярилцлага хэлбэрээр тодруулга авч, иргэн М.Гэрлээд 2025 оны 12 дугаар сарын 03-ны 1/1047 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн байна.

Мэргэжилтэн Н.Дүнжиймаа иргэний гаргасан гомдлын дагуу хийсэн хяналт шалгалтыг удирдлагын баталсан удирдамжгүйгээр гүйцэтгэсэн.

Энэ нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дах заалт “Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан асуудлаар гаргасан өргөдөл, гомдлыг уг хуульд заасан журмаар шийдвэрлэнэ”, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт “Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх

хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу хийх”, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаан дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.6 дах заалт “Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ”, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/27 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Биеийн тамир, спортын улсын хорооны дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ын 2.5 дах заалт “Төлөвлөгөөт дотоод хяналт шалгалтыг байгууллагын жилийн гүйцэтгэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулж ажиллах бөгөөд төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу хийж гүйцэтгэнэ” гэснийг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

5.2 Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн Б/79 дугаар тушаалаар Х.Цэрэндэжидийг нярвын ажилд томилж Биеийн тамир, спортын улсын хорооны даргын Б/132 дугаар тушаалаар , 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр ажлаас чөлөөлсөн. Ажлаас чөлөөлөгдөх үндэслэл нь албан тушаалын тодорхойлолтын заасан мэргэжлийн (310901) код зөрүүтэй мэргэжлийн шаардлага хангахгүй гэсэн үндэслэлээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны 01/50 дугаартай албан шаардлагын дагуу чөлөөлсөн.

Х.Цэрэндэжид ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш буюу 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Боловсролын яаманд өргөдөл гаргаж өөрийн эзэмшсэн мэргэжил нь нярвын ажлын байранд тавигдсан мэргэжилтэй индекс дүйцэж байгаа тухай лавлагааг Боловсролын яамны 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 03/5811 дүгээр албан бичгээр авч, ажилд орох өргөдлөө гаргасан байна. Өргөдлийн дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний Б/146 дугаар тушаалаар түүний өмнө эрхэлж байсан албан тушаал буюу нярвын ажилд томилсон. Байгууллагын цалингийн тооцооны хүснэгтээр Х.Цэрэндэжидэд 2025 оны 11 дүгээр сард 4 хоногийн 461.9 мянган төгрөгийн цалин хөлс тооцон олгосон нь ажилд дахин томилогдсон хугацааны дагуу олгох ёстой цалинтай тохирч байна.

Байгууллагын ерөнхий нягтлан бодогч Б.Оюунцэцэг өөрийн удирдлагад ажиллах ажилтныг шууд томилох эрхгүй бөгөөд албан тушаалаа урвуулан ашигласан эсэхийг шалгах чиг үүрэг шалгалтын бүрэлдэхүүнд байхгүй тул холбогдох хууль, хяналтын байгууллагад хандахыг зөвлөж байна.

Зургаа. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн Б/147 дугаар тушаалаар даргын туслах Б.Дашдавааг албан тушаалаас чөлөөлсөн тухай шалгахад:

Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын сайдад хандан 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр гаргасан иргэн М.Гэрлээгийн гомдолд “Биеийн тамир, спортын улсын хорооны даргын туслах Д.Дашдаваагийн ажлын байран дээр согтууруулах ундаа хэрэглэсэн байсныг нотлох баримтаар гаргаж өгсөн атал зохион хяналт,

шалгалтыг журмын дагуу явуулаагүй, мөн 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн Б/147 дугаар тушаалаар Д.Дашдавааг чөлөөлсөн нь буруу ба гарын үсэг зурсан албан тушаалтнуудад хариуцлага тооцох өгнө үү.. гэж гомдолдоо дурдсан.

Тус гомдлын дагуу тодруулахад Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн Б/147 дугаар тушаалаар даргын туслах Б.Дашдавааг өөрийн хүсэлтээр ажлаас нь чөлөөлсөн. Харин түүний ажлын байран дээрээ согтууруулах ундаа хэрэглэсэн байсныг нотлох баримтыг иргэн М.Гэрэлээ тушаал гарснаас хойш буюу 12 сарын 01-нд Биеийн тамир, спортын улсын хороонд ирүүлсэн.

Даргын туслах Д.Дашдаваа нь өөрийн хүсэлтээрээ ажлаас чөлөөлөгдсөн нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх заалт “Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ажилтан санаачилж цуцлах эрхтэй” гэсэнтэй нийцсэн байна.

Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаатай холбоотой шийдвэрийг Хөдөлмөрийн тухай хуулийн 161 дүгээр зүйлийн 161.1 дэх заалт “Хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг энэ хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хуулийн дагуу хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ” гэсний дагуу Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчид хандаж шийдвэрлүүлэх боломжтой юм.

ДҮГНЭЛТ

Дотоод хяналт шалгалтаар иргэн М.Гэрэлээгийн гомдолд дурдагдсан асуудлаар Биеийн тамир, спортын улсын хорооны зарим үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянан шалгалтыг хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдлоо. Үүнд:

1. М.Гэрлээгийн Биеийн тамир, спортын улсын хороонд ажиллаж байх үеийн буюу 2024 оны жилийн эцсийн Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх үнэлгээний хуудсыг нотлох баримтаар Шүүхэд хүргэгдээгүй байна.
2. Мэргэжилтэн М.Гэрлээгийн Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшнийг 73.78 хувиар үнэлж Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Ж.Баасансүрэн гарын үсэг зурсан ба бусад холбогдох албан тушаалтан гарын үсэг зураагүй, баталгаажуулаагүй байна. Энэ нь Засгийн 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшнийг үнэлэх журам"-ын 2.11 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
3. Спортын хэлтсийн мэргэжилтэн Э.Хүрэлчулуун, Д.Мөнхбаяр, М.Наранбадрах нарын 3 албан хаагчийн Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл үр дүн мэргэшлийн түвшнийг үнэлэх үнэлгээний хуудаст үнэлгээний багийн гишүүд үнэлгээ өгч гарын үсэг зурсан, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Баттулга гарын үсэг зурж байгууллагын тамгаар баталгаажуулсан.

4. Дээрх 3 мэргэжилтэнд 2024 оны үр дүнгийн урамшуулал болон БТСУХ-ны даргын 2024 оны А/749 дүгээр "Нэмэлт санхүүжилтийн орлогыг зарцуулах тухай" тушаалаар тус бүр 2,400.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 51.1.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2 дахь заалтын дагуу олгосон тул хууль тогтоомжид нийцсэн байна.
5. Мэргэжилтэн Н.Дүнжиймаагийн эзэмшсэн мэргэжил нь Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 309 дүгээр тогтоолын 41 дүгээр хавсралтаар батлагдсан "Орон нутгийн байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн"-ний албан тушаалын мэргэжлийн тусгай шаардлагыг хангахгүй, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам" -ын 4.2 дахь заалтыг зөрчсөн.
6. Мэргэжилтэн Н.Дүнжиймаа иргэний гаргасан гомдлын дагуу хийсэн хяналт шалгалтыг удирдлагын баталсан удирдамжгүйгээр гүйцэтгэж, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаан дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.6 дахь заалт, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/27 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Биеийн тамир, спортын улсын хорооны дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын 2.5 дахь заалтыг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

Дотоод хяналт, шалгалтын дүнгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах дотоод хяналт шалгалтыг сайжруулан ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгтэд даалгаж байна.

Зөвлөмж 1. БТСУХ-нд мэргэжилтнээр ажиллаж байсан иргэн М.Гэрлээгийн 2024 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл үр дүн мэргэшлийн түвшний үнэлгээг Засгийн 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшнийг үнэлэх журам"-ын 2.11 дэх заалтын дагуу хийж дуусган, түүнд хүргүүлэх;

Зөвлөмж 2. Иргэн М.Гэрэлээгийн гомдлын дагуу даргын туслахын ажлын байран дээрээ согтууруулах ундаа хэрэглэсэн байсан тухай, ерөнхий нягтлан бодогч албан тушаалаа урвуулан ашиглаж ЗГХЭГ-ын албан даалгаврын хүрээнд ажлаас чөлөөлөгдсөн иргэнийг нярваар ажиллуулсан тухай гомдлуудыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаан дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.6 дахь

заалтыг үндэслэн удирдамж баталж, дотоод хяналт шалгалтыг хийж хариуг хүргүүлэх;

Зөвлөмж 3. Мэргэжилтэн Н.Дүнжиймаагийн эзэмшсэн мэргэжил хашиж буй албан тушаалын тодорхойлолтын мэргэжлийн тусгай шаардлага хангаагүй асуудлыг Төрийн албаны тухай хуулийн дагуу шийдвэрлэх;

Дотоод хяналт шалгалтын дүгнэлтэд үндэслэн өгсөн зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэх.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ